

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллага сонгох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.9 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийг сонгосугай.
2. “Шинэ их тэрбум аудит” ХХК-тай байгуулах гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Ж.Ганхүлэг/-д олгосугай.
3. Хөндлөнгийн аудитын байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөх, тайланг төлөвлөсөн хугацаанд нийтлэхэд шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Ганхүлэг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч. Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай


Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.9 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12 сарын 09 өдрийн 669 тоот тогтоолын дагуу Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож компанийн үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орсон тул компанийн шинэчилсэн дүрмийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Ганхүлэг)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



Тандэм Инвэст ББСБ ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 1 дугаар сарын 02-ны өдрийн
02 тоот тогтоолын Хавсралт №1

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ийн дүрэмд орох өөрчлөлтүүд:

Харьцуулалтууд		
Хуучин	Өөрчлөлт	Тэмдэглэл
3.1 ББСБ нь “Иргэний хууль”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”болон холбогдох бусад хууль тогтоомж, журмаар зөвшөөрсөн дараах ажил, үйлчилгээг эрхэлнэ. 3.1.1 Зээлийн үйл ажиллагаа 3.1.2 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх 3.1.3 Гадаад валютын арилжаа 3.1.4 Итгэлцлийн үйлчилгээ	3.1 ББСБ нь “Иргэний хууль”, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”болон холбогдох бусад хууль тогтоомж, журмаар зөвшөөрсөн дараах ажил, үйлчилгээг эрхэлнэ. 3.1.1 Зээлийн үйл ажиллагаа 3.1.2 Гадаад валютын арилжаа 3.1.3 Итгэлцлийн үйлчилгээ	Өөрчлөлт